



Төлсөн Авснаа Нийтэл эвсэл
Publish What You Pay

ТАН ЭВСЛИЙН ДҮРЭМ

Нэгдүгээр бүлэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Төлсөн Авснаа Нийтэл /ТАН/ эвсэл нь Монгол Улсын 16 төрийн бус байгууллагуудын санаачилга, хамтын ажиллагаа, итгэл үнэмшилд тулгуурласан шийдвэрээр 2006 онд байгуулагдсан. Үйл ажиллагаагаа илүү өргөн хүрээтэй, үр дүнтэй болгох, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын (цаашид ОУИТБС гэх) ОУ-ын дүрэм, шаардлагад 2011 онд өөрчлөлт орсонтой холбогдуулан, 2012 оны бүх гишүүдийн хурлаар дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байгааг хэлэлцсэн. Эвслийн гишүүнчлэлийн цар хүрээг өсгөх, байгууллагаа улам бэхжүүлэх, өргөн суурьтай хүчтэй үйл ажиллагааг үндэсний хэмжээнд далайцтай өрнүүлэх зорилгоор дахин нэмэлт, өөрчлөлт оруулсан энэ дүрэм нь Бүх гишүүдийн хурлаар батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.2 ТАН эвсэл нь энэ дүрмийг хүлээн зөвшөөрч, ардчилсан зарчмын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн иргэний нийгмийн байгууллагуудын сайн дурын, чөлөөт нэгдэл мөн.
- 1.3 ТАН эвсэл нь төрийн байгууллага болон аливаа улс төр, эдийн засгийн явцуу ашиг сонирхлоос хараат бус, үл намчирхдаг, нийгэмд үйлчилдэг, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудын эвсэл байна.
- 1.4 Эвслийн оноосон нэр нь монгол хэлээр “Төлсөн Авснаа Нийтэл,” англи хэлээр “Publish What You Pay” байна. (Цаашид энэ дүрэмд “Эвсэл” гэнэ).
- 1.5 Эвсэл нь өөрийн бэлгэдэл, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.
- 1.6 Эвсэл нь өөрийн үнэт зүйл, зарчимтай байна. Эвслийн бүх бодлого, стратеги, шийдвэр, үйл ажиллагаа нь энэ дүрэмд тусгагдсан үнэт зүйл, зарчимд суурилна.
- 1.7 Эвсэл нь Монгол улсын Үндсэн хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Монгол улсын бусад хууль болон ОУИТБС-ын үндэсний дүрэм, санамж бичиг, ОУ-ын дүрмийн шаардлага, түүний үзэл санаа, зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.
- 1.8 Эвслийн жилийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан холбогдох байгууллагууд, олон нийт, гишүүдэд нээлттэй байна.
- 1.9 Эвслийн албан ёсны хаяг тухайн жилийн зохицуулагч байгууллагын хаягаар хаяглагдаж, санхүүгийн харилцах данс мөн зохицуулагч байгууллагын харилцах данс ашиглагдана.
- 1.10 Эвслийг Монгол Улсад бүртгэлтэй төрийн бус доорх байгууллага үүсгэн санаачлав. Үүнд:
 1. Ариун суварга хөдөлгөөн
 2. Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо
 3. Бүс нутгийн байгаль хамгааллын Хангай хан сүлжээ
 4. Зориг сан
 5. Ил тод байдал сан
 6. Миний монголын газар шороо хөдөлгөөн

7. Монголын байгаль орчныг хамгаалах холбоо
8. Монголын жижиг дунд уурхайнуудын Монмин нийгэмлэг
9. Монголын ногоонтны хөдөлгөөний сүлжээ - Сэлэнгэ аймгийн зөвлөл, Ойн менежментийн холбоо
10. Монголын тул хамгаалах нийгэмлэг
11. Мэдээлэл олон нийтийн харилцааны Инфорум төв
12. Нээлттэй нийгэм форум
13. Онги голынхон хөдөлгөөн
14. Онон - Улз голынхон хөдөлгөөн
15. Уугуул хөдөлгөөн
16. Хүний эрх хөгжил төв багтсан болно.

Хоёрдугаар бүлэг. БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

- 2.1 *Сайн дурын гишүүнчлэлд суурилна:* Эвслийн үнэт зүйлс, зарчим, бодлого, стратеги, дүрмийг хүлээн зөвшөөрч, гишүүнчлэлийн шалгуурыг хангасан, иргэний нийгмийн байгууллагыг эгнээндээ нэгтгэхэд нээлттэй байна.
- 2.2 *Хамтын удирдлагын зарчмыг хэрэгжүүлнэ:* Өөрийн удирдлагыг хамтын удирдлагын зарчмаар хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа чөлөөтэй, бие даан явуулна. Гишүүд тэгш эрхтэйгээр, итгэлцэл, хүндэтгэлд суурилан, харилцан ойлголцлыг эрхэмлэж ажиллана. Гишүүдийн бие даасан байдлыг хүндэтгэж, дотоод хэрэгт нь үл оролцоно.
- 2.3 *Ил тод, нээлттэй, ардчилсан зарчмаар ажиллана:* Эвсэл нь ардчиллын бүхий л үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлнэ. Эвслийн аливаа бодлого, шийдвэр, үйл ажиллагаа нь гишүүд, олон нийтэд ил тод, нээлттэй байж шийдвэрийг олонхийн саналаар гаргадаг байна
- 2.4 *Манлайллыг хөгжүүлэхэд үйлчилнэ:* Гишүүдийг эвслийн эрхэм зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх санаачилга гаргах, хэрэгцээ тодорхойлох, туршлага сургамжаа хуваалцах, шийдлийг хамтдаа төлөвлөж хэрэгжүүлэх, өөрчлөлт шинэчлэлийн төлөө нөлөөлж чаддаг болгоход үйлчилнэ.
- 2.5 *Оролцоо, олон ургальч үзэлд тулгуурлана:* Аливаа бодлого, шийдвэрийг гарахаас нь өмнө оролцож, нээлттэй, бүтээлч хэлэлцүүлэг өрнүүлж, зөвшилцөлд хүрэх зарчмаар хамтын шийдвэрээ гаргаж, төлөөллөө хангана.
- 2.6 *Нээлттэй, тэгш хамтын ажиллагаа, өргөн түншлэлийг хөгжүүлнэ:* Эвсэл нь төрийн ба иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээлэл, олон улсын байгууллага, хувийн хэвшил, зэрэг бүхий л талуудтай зорилгынхоо хүрээнд үр нөлөөтэй хамтран ажиллахад нээлттэй байна.
- 2.7 *Хариуцлага, үр дүнг шаардах иргэдийн чадавхыг хөгжүүлнэ:* Эвсэл нь МУ-ын ОУИТБС-ын тайланг талууд тайлагнах, мэдээлэх үйл явц, түүний гүйцэтгэлд хяналт тавихад иргэдийн оролцоог хангахад нөлөөлж ажиллана. Мөн орлогын менежментэд хяналтаа тогтоож иргэний нийгмийн байгууллагуудын чадавхийг хөгжүүлэхэд нөлөөлж ажиллана
- 2.8 *Шударга ёс, хуулийг удирдлага болгоно:* Эвсэл нь шударга ёсыг удирдлага болгон, үйл ажиллагаагаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж, ОУ-ын ОУИТБС-ын дүрэм, шаардлагад нийцүүлэн явуулна.

Гуравдугаар бүлэг. АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

- 3.1 Эвслийн алсын хараа нь олборлох үйлдвэрлэлийн орлогын удирдлагыг ил тод нээлттэй болгож, түүний үр ашиг тэгш, шударга хувиарлагдан хүний хөгжил, хүний ая тухтай амьдрах боломжийг хангах нийгмийг төлөвшүүлэхэд оролцох явдал мөн.
- 3.2 Эвслийн эрхэм зорилго нь ОУИТБС-ыг эх орондоо хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавьж үнэлгээ өгөх, түүнийг олон нийтэд ил тод сурталчилан танилцуулж иргэд, иргэний нийгмийн оролцоог өргөжүүлэх

Дөрөвдүгээр бүлэг. ЗОРИЛТУУД

Эвсэл нь эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан үндсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ:

- 4.1. ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцогч үндсэн талууд болох Монгол улсын засгийн газар, олборлох компаниудтай санаачилгын зарчим шалгуурын хүрээнд идэвхитэй хамтран ажиллаж, Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсэгт төлөөллөө томилон үр дүнтэй ажиллуулах;
- 4.2. ОУИТБС-ын хэрэгжилтэнд иргэний нийгмийн оролцоог өргөжүүлэх, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэх;
- 4.3. Олон улсын ОУИТБС-ын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, олон улсын эвсэл болон Бүс нутгийн сүлжээнд нэгдэх замаар үйл ажиллагаагаа сайжруулан тэдгээрийн туршлага, арга барилыг нэвтрүүлэх;

Тавдугаар бүлэг. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 5.1 Эвсэл нь үндсэн зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхийн тулд дараах хүрээнд үйл ажиллагаагаа явуулна:
 - 1) ОУИТБС-ын хэрэгжилт түүний үйл явцад хяналт тавьж, үнэлгээ өгөх;
 - 2) ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр уулзалт, сургалт, ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах;
 - 3) Ажлын хэсэг, хороод, шинжээчдийн хэсэг байгуулах;
 - 4) ОУИТБС-тай холбоотой аливаа баримт бичиг, төсөл, хөтөлбөрт үнэлгээ дүгнэлт өгөх;
 - 5) Олон нийтэд хандсан үйл ажиллагаа явуулах кампанит ажил зохион байгуулах;
 - 6) Иргэний нийгмийн байгууллагууд, иргэдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
 - 7) Ном, тайлан, товхимол, мэдээллийн хуудас зэрэг хэвлэмэл материал гаргах;
 - 8) Вэб хуудас, мэдээллийн сан ажиллуулах;
 - 9) Олон улсын туршлагыг судалж, хэрэгжүүлэх, гадаадын байгууллагуудтай туршлага солилцох;
 - 10) Төрийн бус байгууллагуудын олон улсын эвсэл болон бүс нутгийн сүлжээний үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;

Зургаадугаар бүлэг. Үйл ажиллагааны хэлбэр

- 6.1 Эвсэл нь үндсэн зорилгоо үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд үндэсний болон олон улсын төрийн ба ТББ болон бусад байгууллагатай дараах хэлбэрээр хамтран ажиллана:
 - 1) Мэдээллээ харилцан солилцох, туршлага, арга зүйгээ хуваалцах;
 - 2) Нийтлэг алсын хараа, ашиг сонирхол, нэгэн зорилгын төлөө хамтран ажиллах;
 - 3) Тэгш эрхтэй, үр дүнтэй түншлэлийг хөгжүүлэх;
 - 4) Зохион байгуулалттай, өргөн суурьтай хөдөлгөөн өрнүүлэх;
 - 5) Нэгдмэл байр суурь, үзэл санаа, зарчимд тулгуурлан шударга ёс, хариуцлагыг шаардах, бодлогод нөлөөлөх;

Долоодугаар бүлэг. ГИШҮҮНЧЛЭЛ

7.1 Гишүүнчлэл

- 1) Эвслийн үнэт зүйлс, зарчим, бодлого, стратеги, дүрмийг хүлээн зөвшөөрч, гишүүнд тавигдах шаардлагыг хангасан аливаа иргэний нийгмийн байгууллага сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэж болно.
- 2) Эвслийн гишүүнд тавигдах шаардлага, зорилго, үнэт зүйл, зарчимд тулгуурлан, гишүүн элсүүлэхдээ нээлттэй бодлого барина.
- 3) Эвсэлд гишүүнээр элсэх бие даасан байгууллага нь удирдлагын багийн шийдвэрээ, эвсэл, сүлжээ, холбоо зэрэг байгууллагуудын нэгдэл нь эвслийн гишүүнээр элсэх тохиолдолд тухайн нэгдлийг төлөөлөх байгууллагуудын бүх гишүүдээрээ хэлэлцүүлсэн хурлын протоколыг гарсан шийдвэрийн хамт Эвслийн зохицуулах зөвлөлд ирүүлнэ.
- 4) Эвсэлд улс төрийн нам, олборлох үйлдвэрлэл эрхлэгч тэдгээрийн эвсэл, тэдгээрийн харьяа болон дэмжигч байгууллагууд гишүүнээр нэгдэхийг ашиг сонирхолын зөрчилтэй гэж үзэн элсэхийг хориглоно.
- 5) Эвсэлд гишүүн элсүүлэх асуудлыг зөвлөлийн нийт гишүүдийн хурлаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагаар зохицуулах зөвлөлийн хурлаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэнэ.

7.2 Эвслийн Гишүүнд тавигдах шаардлага

- 1) Эвслийн үнэт зүйл, зарчим, дүрэм, бодлого, стратегийг хүлээн зөвшөөрсөн;
- 2) Шударга ёс, тэгш эрхийг эрхэмлэж, өдөр тутмын үйл ажиллагаандаа баримталдаг;
- 3) Аливаа хүчирхийллээс ангид байж, итгэлцэл, хүндэтгэл, харилцан ойлголцол, зөвшилцлийг эрхэмлэдэг;

7.3 Гишүүний эрх

7.3.1 Эвслийн гишүүн нь дор дурдсан нийтлэг эрхийг эдэлнэ:

- 1) Эвслээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд хамрагдах, өөрийн төлөөлөгчийг оролцуулах;
- 2) Эвслийн зохицуулах зөвлөл, хяналтын зөвлөлд нэр дэвшүүлэх, нэр дэвших;
- 3) ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсгийн гишүүнд нэр дэвших, дэвшүүлэх;
- 4) Эвслээс шаардлагатай мэдээлэл, аргазүйн зөвлөгөө, дэмжлэг, туслалцаа авах;
- 5) Эвслийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт хийх, үнэлгээ өгөх;
- 6) Эвслийн удирдах багт өөрийн байгууллага, гишүүдийн эрх ашиг, үйл ажиллагаатай холбоотой тодорхой санал, хүсэлтийг хэлэлцүүлэх;
- 7) Эвслийн гишүүнчлэлээс гарах;

7.3.2 Гишүүн байгууллага нь 7.3.1-д заасан гишүүний нийтлэг эрхийн зэрэгцээ Бүх гишүүдийн хуралд төлөөлөгч сонгох, саналын эрхтэй оролцох эрхийг эдэлнэ.

7.4 Гишүүний үүрэг

7.4.1 Эвслийн гишүүн нь дор дурдсан нийтлэг үүргийг хүлээнэ:

- (а) Эвслийн дүрмийг сахин биелүүлж, стратеги, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай манлайлан оролцох;
- (б) Эвсэл болон түүний гишүүнийг үндэслэлгүйгээр гүтгэх, доромжлох, сөрөг сурталчилгаа явуулах, бусадтай тохиролцох, үгсэн хуйвалдах зэрэг ямар нэгэн байдлаар нэр хүндэд нь халдаж, дарамт шахалт үзүүлэхгүй байх;

- 7.4.2 Гишүүн байгууллага нь Эвслээс санал авахаар хүргүүлсэн аливаа асуудлуудыг байгууллагаараа хэлэлцүүлж, саналыг нэгтгэн, хариу мэдээлэх;
- 7.4.3. Гишүүн байгууллага нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, эвслийн жилийн ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайлангаа дараа оны 01 сард багтаан зохицуулагчид хүргүүлэх;
- 7.5 ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсэгт эвслийг төлөөлж буй гишүүний үүрэг, хариуцлага
- 7.5.1 ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсэгт эвслийг төлөөлж буй гишүүн нь Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсгийн хуралдаанд бүрэн идэвхтэй оролцож, хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаар эвслийн гишүүдэд мэдээлэх;
- 7.5.2 ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх бодлогын тодорхой асуудлаар Эвслийн баримтлах байр суурийг урьдчилан хэлэлцэж тодорхойлсон байх;
- 7.5.3 ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсгийн хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 3-аас дээш удаа оролцоогүй гишүүнийг эргүүлэн татаж болно.
- 7.6 Гишүүнчлэлээс гарах, чөлөөлөх
- 7.6.1 Гишүүнчлэлээс гарах нь гишүүн бүрт нээлттэй байх ба гарах тухайгаа Зохицуулагчид 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Зохицуулагч зохицуулах зөвлөлд энэ тухай танилцуулснаар тухайн гишүүнийг Эвслээс гарсанд тооцно.
- 7.6.2 Гишүүнийг дор дурдсан тохиолдолд Эвслийн гишүүнчлэлээс чөлөөлнө:
- 1) Эвслийн зарчим, зорилго, үйл ажиллагааг зөрчсөн;
 - 2) Эвслийн нийтлэг эрх ашиг, эв нэгдэлд харш, нэр хүндийг гутаахад чиглэсэн үйл ажиллагаа санаатай явуулсан, дэмжсэн, энэ төрлийн үйл ажиллагаа зохион байгуулсан, оролцсон;
 - 3) Эвслийн нэрийг ашиглан хууль бус үйлдэл хийснийг хяналтын зөвлөл тогтоосон бол;
 - 4) Зохицуулах зөвлөлийн зөвшөөрөлгүйгээр Эвслийн нэрийн өмнөөс мэдэгдэл хийсэн тэр нь ноцтой гэдгийг хяналтын зөвлөл тогтоосон бол;
- 7.6.3 Энэхүү дүрмийн 7.5.2-т заасан үндэслэлээр Эвслийн гишүүнчлэлээс чөлөөлөх тохиолдолд Хяналтын зөвлөл хянан үзэж, дүгнэлт гаргасан байна.
- 7.6.4 Эвслийн гишүүнчлэлээс чөлөөлөх асуудлыг хяналтын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн зохицуулах зөвлөлөөр хэлэлцэж, хуралд оролцсон нийт гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
- 7.6.5 Эвслээс өөрийн хүсэлтээр гарч, чөлөөлөгдөж байгаа гишүүнд энэ тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн Эвслийн эрх барих, удирдах бүтцэд өөрийн төлөөлөлтэй байх болон бусад эрх, үүрэг дуусгавар болно.

Наймдугаар бүлэг. УДИРДЛАГА, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1 Эвслийн бүтэц

Эвсэл нь дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулна:

А. Бүх гишүүдийн хурал

- В. Зохицуулах зөвлөл
- С. Хяналтын зөвлөл
- Д. Эвсэл нь дэргэдээ Зөвлөх бүлэгтэй байж болно.

8.2 Бүх гишүүдийн хурал

- 1) Эвслийн эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байна. Бүх гишүүдийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулна.
- 2) Бүх гишүүдийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг зохицуулах зөвлөлийн хурлаас тогтоож, хурлын товыг 10 хоногоос доошгүй хугацааны өмнө гишүүдэд мэдэгдэнэ.
- 3) Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн батлах баримт бичгийн төслүүдийг урьдчилан боловсруулж, 5 хоногийн өмнө гишүүдэд онлайнгаар хүргүүлсэн байна.
- 4) Ээлжит бус Бүх гишүүдийн хурлыг зохицуулах зөвлөлийн нийт гишүүдийн буюу гишүүн байгууллагуудын тавиас дээш хувийн саналын шаардлагаар хуралдуулж болно.
- 5) Ээлжит бус Бүх гишүүдийн хурлыг хуралдуулах шаардлага тавигдсан тохиолдолд шаардлага тавигдсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор зохицуулах зөвлөл зарлан хуралдуулна.
- 6) Ээлжит бус Бүх гишүүдийн хурлын тов, хэлэлцэх асуудал, зарлах хугацаа болон төлөөлөгч сонгох зарчим нь ээлжит Бүх гишүүдийн хуралтай адил байна.
- 7) Бүх гишүүдийн хуралд гишүүдийн олонхи нь оролцсон тохиолдолд тус Бүх гишүүдийн хурлыг хүчин төгөлдөр гэж үзнэ. Бүх гишүүдийн хуралд гишүүн байгууллага бүр нэг саналтай оролцоно.
- 8) Бүх гишүүдийн хурлаас гарах шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.

Бүх гишүүдийн хурал дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- 1) Жилийн төлөвлөгөө хэлэлцэж батлах, тайланд дүгнэлт гаргах,
 - 2) Эвслийн дүрэм, түүнд нэмэлт оруулах, өөрчлөлтийг батлах;
 - 3) Эвслийн бодлого, стратегийг батлах;
 - 4) Зохицуулах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх, үнэлэлт өгөх;
 - 5) Хяналтын зөвлөлийг сонгох, чөлөөлөх, тайланг хэлэлцэх, үнэлэлт өгөх;
 - 6) Эвслийг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;
 - 7) Эвслийн гишүүдээс нэр дэвшүүлснээр ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсэгт Эвслийг төлөөлөх гишүүнийг (Зохицуулах зөвлөлийн гишүүдээс гадна) томилох.
 - 8) Энэ дүрмийн 7.5.3-т заасны дагуу ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсгийн гишүүнээс эргүүлэн татах.
- 9) Бүх гишүүдийн хуралдааныг чиглүүлэх, түүний явц, зохион байгуулалттай холбогдсон асуудлыг шийдвэрлэх, сонгууль удирдан явуулах, хурлын шийдвэрийг хэлбэржүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэх хуралдаан даргалагчийг тухайн хуралдаанаас сонгоно.
 - 10) Хуралдааны явцыг протоколд тэмдэглэж, хуралдаан даргалагч, протокол хөтлөгч нар гарын үсэг зурна. Хурлын шийдвэрийг хурал даргалагч гарын үсэг зурж баталгаажуулна.

8.3. Зохицуулах зөвлөл

1. Зохицуулах зөвлөл нь хоёр жилээр сонгогдон, хамтын удирдлагын зарчмаар ажиллана.
2. Зохицуулах зөвлөл нь 7-оос дээш гишүүн байгууллагын төлөөллийн бүрэлдэхүүнтэй, тус бүр саналын нэг эрхтэй байна.

3. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг хоёр жил тутамд сэлгээ хийх ба нэг удаа улиран сонгогдож болно.
4. Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгохдоо төв, орон нутаг гэх мэт газар зүйн байрлалын төлөөллийг хангах зарчмыг баримтална.

Зохицуулах зөвлөлийн хурал:

1. Зохицуулах зөвлөл нь хуралдааныхаа дэгийг анхдугаар хурлаараа баталж мөрдөнө. Хуралдааны явцыг протоколд тэмдэглэх бөгөөд хуралдааны тэмдэглэлээр шийдвэр гарна
2. Зохицуулах зөвлөлийн хуралдааныг зохицуулагч даргална. Эвслийн зохицуулагч тухайн хуралдааныг даргалах боломжгүй бол зөвлөлийн гишүүд дундаасаа хурлын даргыг сонгоно.
3. Зохицуулах зөвлөл online-аар хуралдаж болох ба хурлын тэмдэглэлд хэлэлцсэн асуудал түүний явцыг баримтжуулан хавсаргана. Online-аар хуралдуулахад зөвлөлийн гишүүн хэлэлцсэн асуудлаар ажлын 5 өдөрт санал ирүүлээгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцож шийдвэр гаргана.
4. Зохицуулах зөвлөлийн гишүүдийн олонхи нь оролцож, шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.
5. Зохицуулах зөвлөлийн гишүүн зарчмын зөрүүтэй саналтай тохиолдолд үндэслэлээ бичгээр тайлбарлаж, протоколд хавсаргана.

1) Зохицуулах зөвлөлийн чиг үүрэг:

- i. Эвслийн бодлого, хэтийн төлөв, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох;
- ii. Эвслийн тухайн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг хэлэлцэж бүх гишүүдийн хуралд оруулах улмаар саналыг авч зохицуулах зөвлөлөөр баталж болно.
- iii. Зохицуулагчийн жилийн ажлын тайлан болон санхүүгийн жилийн тайлан тэнцлийг хэлэлцэж батлах;
- iv. Зохицуулагчийг сонгох, чөлөөлөх, түүнд олгох цалин, урамшууллыг тогтоох,
- v. Эвслийн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах талаарх Зохицуулагчийн эрх хэмжээг тогтоох;
- vi. Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах;
- vii. Бүх гишүүдийн хурлын завсарлагаар шинээр гишүүн элсүүлэх шийдвэр гаргах;
- viii. Бүх гишүүдийн хурлын бүрэн эрхэд хамаарахаас бусад бүх асуудал;
- ix. Хөрөнгө босгох, нөөцийг дайчлах бодлогыг тодорхойлох, дэмжлэг үзүүлэх;

2) Зохицуулах зөвлөлийн гишүүний хүлээх үүрэг хариуцлага:

- i. Эвслийн үнэт зүйл, зарчимд үнэнч байж, Эвслийн эрх ашгийг хувийн, болон байгууллагын сонирхлоос дээгүүр тавих;
- ii. Эвслийн хөрөнгө, санхүүгийн болон бусад чадавхийг бэхжүүлэхэд анхаарлаа хандуулж, тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх;
- iii. Өөрийн байгууллага, салбарын эрх ашгийн үүднээс бус Эвслийн алсын хараа, нийтлэг эрх ашгийн үүднээс асуудалд хандах;
- iv. Эвслийн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллах, гишүүдэд манлайлал үзүүлэх
- v. ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсэгт Эвслийг төлөөлөх.

3) Эвслийн зохицуулагч

- i. Зохицуулах зөвлөлийн гишүүд дундаасаа эвслийн зохицуулагчийг хоёр жилийн хугацаагаар сонгоно. Зохицуулагчийг нууц санал хураалтаар, зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар сонгоно.

- ii. Эвслийн зохицуулагчийн бүрэн эрхийн хугацааг нэг удаа дахин үргэлжлүүлэн сунгаж болно.

Зохицуулагч нь дор дурдсан эрх эдлэж, үүрэг хүлээнэ.

1. Эвслийн байнгын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, бүх гишүүдийн хурал болон Зохицуулах зөвлөлд ажлаа хариуцан тайлагнана.
2. ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсэг болон Олон улсын Эвслийн гишүүдээс нэр дэвшүүлснээр ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, Олон талт оролцогчдын ажлын хэсэгт Эвслийг төлөөлөх гишүүнийг байгууллагуудад Эвслийг төлөөлнө.
3. Зохицуулах зөвлөлөөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд эвслийн мөнгөн хөрөнгийг захиран зарцуулна.
4. Санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг хагас, бүтэн жилээр боловсруулан эвслийн үндсэн зорилгын болон жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг зохион байгуулж Зохицуулах зөвлөлд болон санхүүжүүлэгч байгууллагад тайлагнана.
5. Эвслийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;
6. Ажлын хэсэг, хороо, шинжээчдийн хэсгийн ажлыг зохион байгуулах;
7. Эвслийн гишүүдэд эвслийн удирдлагаас гаргаж буй шийдвэрийн талаар мэдээлж байх;
8. Сүлжээний гишүүдийн оролцоог хангах, хамтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;
9. Гишүүнчлэлийг өргөжүүлэх, хөгжүүлэх;

4) Эвслийн шийдвэр гаргах журам Шийдвэр гаргахад дараах нийтлэг зарчмыг баримтална:

- i. Эвслийн суурь зарчмуудыг баримталж гарсан шийдвэр хүчин төгөлдөр байна.
- ii. Хувь хүнтэй холбоотой асуудлыг нууцаар, бусад асуудлыг илээр санал хурааж шийдвэрлэнэ.

8.4. Хяналтын зөвлөл

1. Хяналтын зөвлөлийг бүх гишүүдийн хурлаас хоёр жилийн хугацаатай сонгоно.
2. Хяналтын зөвлөл 3 гишүүн байгууллагын төлөөллөөс бүрдэнэ
3. Дүрмийн хэрэгжилтэд хяналт тавина
4. Хяналтын зөвлөл зохицуулах зөвлөлийн хуралд оролцож болох бөгөөд саналын эрхгүйгээр оролцож ажиглалт хийж болно.
5. Хяналтын зөвлөл эвслийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хяналт үнэлгээ хийж тайланг бүх гишүүдийн хуралд тайлагнана.
6. Гишүүдийн гомдол маргааныг шийдвэрлэнэ.
7. Байгууллагын эд хөрөнгийн зарцуулалт үйл ажиллагаанд хяналт тавина.

Есдүгээр бүлэг. САНХҮҮЖИЛТ

9.1 Эвсэл нь дараах эх үүсвэрээс санхүүжинэ:

- i. Гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- ii. Төслийн болон гэрээт ажлын санхүүжилт;
- iii. Дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанаас олсон орлого;
- iv. Хуулиар хориглоогүй бусад орлого.

- 1) Эвсэл нь олсон орлогоо зөвхөн Дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхэд зориулан зарцуулна.

*Төлсөн авснаа нийтэл эвслийн дүрэм.
Бүх гишүүдийн хурлаар нэмэлт, өөрчлөлт оруулав.
2017 оны 11-р сарын 2-ны өдөр*

- 2) Эвслийн орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөх зэргийг хориглоно.
- 3) Зохицуулах зөвлөлийн гишүүд, Зохицуулагч нь Эвслийн өмч хөрөнгөөр хувийн ашиг олоход чиглэсэн санхүүгийн буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 4) Аливаа улс төрийн үйл ажиллагааг дэмжиж нам, эвсэлд хөрөнгө, хандив өгөхийг хориглоно.
- 5) Санхүүгийн тайлан тэнцлийг холбогдох хууль, журмын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд холбогдох байгууллагад тайлагнана.

Аравдугаар бүлэг. ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

- 10.1 Эвслийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн, гишүүдийн гуравны хоёрын саналаар шийдвэрлэнэ.
- 10.2 Өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбоотойгоор үүссэн эд хөрөнгийн шинжтэй харилцааг Төрийн бус байгууллагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн Зохицуулах зөвлөл шийдвэрлэнэ.

ТАН эвсэл
2012 он